



Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан /ҮАГ-ГАГ/2017/09-ГА /



ГХУС ажил үр дүнтэй
хэрэгжиж байгаа боловч
төсвийн төлөвлөлт,
санхүүжилт хуулийн
дагуу хийгдэхгүй байна.

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	Бүлэг 1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.	6-10
Аудитын менежер Х.Наранцацрал	Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг оновчтой тогтоон ажилласан байна.	6-7
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.	7-8
Аудитор Д.Должинсүрэн	Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн ялтай хүмүүсд захиргааны хяналт сайн тавигдаж байна.	9
	Гэмт хэргийн талаар иргэдээс төлбөртэй мэдээлэл авахгүй байна.	10
	ГХУС ажилтай холбоотой сургалт, сурталчилгаа үр дүнтэй зохион байгуулагдаж байна	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Бүлэг 2. ГХУС ажлын арга хэлбэр үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч төсөв хөрөнгө хүрэлцээгүйн улмаас зарим ажил хийгдэхгүй байна	11-14
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү.	ГХУС ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.	11-12
www.audit.mn	ГХУС ажлыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.	12-14
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	ГХУСАЗЗ, ГХУССЗ-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажил хангалтгүй байна.	14
	Бүлэг 3. ГХУС үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдахгүй байна.	14-17
	ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасан хэмжээнд төлөвлөхгүй байна.	14-15
	2015, 2016 онуудад ГХУС ажилд зарцуулсан төсвийн 17.8 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.	15-17
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн	17

2017 оны 10 дугаар сар	<i>хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.</i>	
	Дүгнэлт	17-18
	Дээд шатны байгууллагад хүргэх санал	18
	Зөвлөмж	18
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар	18
	Тайлан баталгаажуулсан тушаал	19-20

ТОВЧИЛСОН ҮГС

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ЭЗ	Эдийн засаг

ГРАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ГРАФИК 1	Гэмт хэргийг төрлөөр нь харьцуулсан байдал /2015-2016 он/
ГРАФИК 2	Эдийн засгийн идэвхгүй хүн ам, гэмт хэргийн тооны харьцаа /2010-2016 он/
ГРАФИК 3	ГХУСАЗЗ-ын зардлын бүтэц
ХҮСНЭГТ 1	Нийт гэмт хэрэгт согтуугаар үйлдсэн гэмт хэргийн эзлэх хувь /2014-2016/ он
ХҮСНЭГТ 2	ЭЗ-ийн идэвхгүй хүн ам, гэмт хэргийн тооны корреляцийн хамаарал
ХҮСНЭГТ 3	Гэмт хэргийн тоог сумдаар харуулсан /2015-2017 он/
ХҮСНЭГТ 4	Гэмт хэргийг төрлөөр нь өсөлтийн хувьтай /2014-2016 он/
ХҮСНЭГТ 5	ГХУСАЗЗ-ын хэрэгжүүлэх чиглэл, үйл ажиллагаа /2015-2017 он/
ХҮСНЭГТ 6	ГХУСАЗЗ-ын хэрэгжүүлэх ажлыг төрлөөр ангилсан судалгаа /2015-2017/
ХҮСНЭГТ 7	252-р тогтоолын хэрэгжилт /2015-2016 он/
ХҮСНЭГТ 8	257-р тогтоолын хэрэгжилт /2015-2016 он/
ХҮСНЭГТ 9	Прокурорын байгууллагын ажлын үзүүлэлт /2015-2016 он/
ХҮСНЭГТ 10	ГХУСАЗЗ-ын төсвийн орлогын судалгаа /2015-2017 он/
ХҮСНЭГТ 11	ГХУСАЗЗ-ын зардлын гүйцэтгэл /2015-2017 он /

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоол, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр;
- Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр;
- Цагдаагийн албаны тухай хууль;
- Прокурорын тухай хууль;
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Замын хөдөлгөөний дүрэм;
- Иргэний хууль;
- Эрүүгийн хууль;
- Прокурорын байгууллагын тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль.

Аудитын хамрах хүрээ: Аудитад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл, Цагдаагийн газар, Прокурорын газар зэрэг байгууллагуудын 2015-2017 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт 3000-3100/-ийг ашиглан ГХУС ажлын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, судалгаа, тайлан зэрэг баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа: Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Д.Должинсүрэн нар 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

УИХ-аас 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” баталсан ба түүнд 2012 оны 1 дүгээр сарын 19, 2013 оны 07 дугаар сарын 05, 2015 оны 12 дугаар сарын 04, 2016 оны 12 дугаар сарын 22, 2017 оны 5 дугаар сарын 18-нд тус тус 5 удаагийн өөрчлөлт оруулсан байна.


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль сахиулах байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд оролцсон өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Цагдаагийн газар, Прокурорын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг байгууллагууд голлох байр суурьтай оролцож байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2015 онд 242 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2016 онд 221 гэмт хэрэг бүртгэгдэж 8.7 хувиар буурсан бол 2017 оны эхний 9 сарын байдлаар 152 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

2017 оны эхний 9 сарын байдлаарх гэмт хэргийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүн амь, залилан, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг нэмэгдэж бусад хэргүүд буурсан үзүүлэлттэй байна.

График 1



2015 онд нийт гэмт хэргийн 28.9 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 25.2 хувийг иргэдийн өмчийн хулгай, 14.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, үлдэж буюу хувийг бусад гэмт хэрэг эзэлж байсан байна.

2016 онд нийт гэмт хэргийн 42.5 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 20.8 хувийг иргэдийн өмчийн хулгай, 10.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, үлдэж буюу хувийг бусад гэмт хэрэг эзэлж байсан байна.

Гэмт хэргийн улмаас 2015 онд 801.5 сая төгрөгийн хохирол учирсан бол 2016 онд 707.6 сая төгрөгийн хохирол учирсан буюу 11.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бүлэг 1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна

1.1 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг оновчтой тогтоон ажилласан байна.


Дундговь аймаг дахь Цагдаагийн газраас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг эдийн засаг, нийгмийн таагүй байдал, ажилгүйдэл, архидан согтууралтай холбоотой гэж дүгнэсэн нь дараах судалгаа, шинжилгээгээр нотлогдож байна. /Хүснэгт 1, 2, график 2/

Хүснэгт 1

Он	Нийт гэмт хэргийн тоо	Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо	Нийт гэмт хэрэгт элэх хувь
2014	260	86	33.1
2015	242	66	27.3
2016	221	66	29.9

2014 онд гарсан нийт гэмт хэргийн 33.1 хувь, 2015 онд гарсан гэмт хэргийн 27.3 хувь, 2016 онд гарсан гэмт хэргийн 29.9 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.

График 2



Эдийн засгийн идэвхгүй хүн амын өөрчлөлт гэмт хэргийн тоонд нөлөөлж буй эсэхэд 2010-2016 оны тоон үзүүлэлтэд корреляцийн шинжилгээ¹ хийлээ.

Тус 2 үзүүлэлтийн корреляцийн хамаарал нь 0.62^2 буюу хүчтэй хамааралтай гарсан байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2

Энэ нь эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өсөхөд гэмт хэргийн тоо өсч, эсрэгээрээ буурахад буурч байгааг илтгэж байна.

	Гэмт хэрэг	Эдийн засгийн идэвхгүй хүн ам
Гэмт хэргийн тоо	1	
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	0.62	1

1.2 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2014 онд 260 гэмт хэрэг гарч 590.8 сая төгрөгийн хохирол учирсан бол 2015 онд 242 болж 18-аар буурсан боловч учирсан хохирлын хэмжээ 801.5 сая төгрөг болж 210.7 сая төгрөгөөр өссөн, 2016 онд 221 гэмт хэрэг гарч 21-ээр буурч учирсан хохирлын хэмжээ 707.6 сая төгрөг болж 93.9 сая төгрөгөөр буурсан байна. Гэмт хэргийн тоо нийт дүнгээр сүүлийн 2 жилд буурсан үзүүлэлттэй байгаа боловч зарим сумдад болон зарим төрлийн гэмт хэрэг өссөн байна. /Хүснэгт 3, 4/

Гэмт хэргийн өсөлтийн хурдыг сумдаар авч үзвэл:

Гэмт хэргийн сүүлийн 2 жилийн дундаж өсөлтийн хурд 80.2 хувь буюу буурсан үзүүлэлттэй байгаа боловч Гурвансайхан, Дэлгэрхангай, Луус, Хулд сумдад гэмт хэргийн өсөлтийн дундаж хурд 100 хувиас дээш буюу өсөлттэй гарсан байна.

Хүснэгт 3

¹ Корреляцийн хамаарал гэдэг нь тохиолдлын хэмжигдэхүүнүүдийн хооронд үүссэн бөгөөд нэгний өөрчлөлт нөгөөд нөлөөлж, түүний дундаж хэмжигдэхүүнийг өөрчилж байгаа статистик хамаарал юм.

² Корреляцийн хамаарал нь $\pm(0.6-0.8)$ хооронд байвал хүчтэй хамааралтай байна гэж үзнэ.

Сумдын нэр	Гэмт хэргийн тоо					
	2014 он	2015 он	Өсөлтийн хувь	2016 он	Өсөлтийн хувь	Дундаж өсөлтийн хувь
Адаацаг	14	11	78.6	9	81.8	80.2
Баянжаргалан	10	6	60.0	9	150.0	94.9
Говь-Угтаал	7	13	185.7	6	46.2	92.6
Гурвансайхан	14	12	85.7	15	125.0	103.5
Дэлгэрхангай	3	10	333.3	7	70.0	152.8
Дэлгэрцогт	18	20	111.1	12	60.0	81.6
Дэрэн	16	9	56.3	10	111.1	79.1
Луус	6	4	66.7	11	275.0	135.4
Өлзийт	10	4	40.0	4	100.0	63.2
Өндөршил	5	4	80.0	3	75.0	77.5
Сайнцагаан	123	118	95.9	109	92.4	94.1
Сайхан-Овоо	4	5	125.0		-	11.2
Хулд	11	8	72.7	13	162.5	108.7
Цагаандэлгэр	8	8	100.0	5	62.5	79.1
Эрдэнэдалай	11	10	90.9	8	80.0	85.3
Нийт	260	242	91.5	221	95.3	80.2

2016 онд Баянжаргалан, Гурвансайхан, Дэрэн, Луус, Хулд сумдад гэмт хэргийн тоо өсөлттэй гарсан бол Сайхан-Овоо суманд гэмт хэрэг гараагүй байна.

Сүүлийн 2 жил дараалан өсөлттэй гарсан гэмт хэрэг байхгүй байгаа нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээ авч ажилласантай холбоотой байна.

Гэмт хэргийн өсөлтийн хурдыг төрлөөр нь авч үзвэл:

Сүүлийн 2 жилд нийт гэмт хэргийн өсөлтийн дундаж хурд 81% хувь буюу буурсан үзүүлэлттэй гарсан боловч хүн амь, булаалт, бусдын бие махбодид гэмтэл учруулах, залилан гэсэн 4-н төрлийн гэмт хэргийн өсөлтийн дундаж хурд 100 хувиас дээш буюу өсөлттэй гарсан байна.

2015 онд хүн амь, булаалт, иргэдийн өмчийн хулгай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, залилан мэхлэх зэрэг 5 төрлийн гэмт хэрэг өмнөх оноос өссөн үзүүлэлттэй гарсан байна.

2016 онд хүн амь, дээрэм, бусдын бие махбодид гэмтэл учруулах, залилан мэхлэх зэрэг 4 төрлийн гэмт хэргийн тоо өссөн байна.

2015 онд өсөлттэй гарсан 5 төрлийн гэмт хэргээс хүн амь, залилан мэхлэх зэрэг 2 төрлийн гэмт хэрэг 2016 онд өссөн, иргэдийн өмчийн хулгай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэсэн 2 гэмт хэргийн тоо буурсан, булаалтын гэмт хэрэг буураагүй байна.

Хүснэгт 4

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо					
	2014 он	2015 он	Өсөлтийн хувь	2016 он	Өсөлтийн хувь	Өсөлтийн дундаж хувь
Хүн амь		1	200.0	4	400.0	282.8
Хүчин	8	2	25.0	1	50.0	35.4

Дээрэм			-	1	200.0	14.1
Танхайрах	12	10	83.3	4	40.0	57.7
Булаалт		1	200.0	1	100.0	141.4
Золгүй учрал	1	1	100.0	1	100.0	100.0
Бусдын бие махбодид гэмтэл учруулах	85	70	82.4	94	134.3	105.2
Малын хулгай	41	31	75.6	16	51.6	62.5
Иргэдийн өмчийн хулгай	53	61	115.1	46	75.4	93.2
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг	33	35	106.1	22	62.9	81.6
Залилан мэхлэх	5	7	140.0	10	142.9	141.4
Бусад	22	23	104.5	21	91.3	97.7
Нийт	260	242	67.7	221	96.9	81.0

Өсөлттэй байгаа гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгахаар тодорхой арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч иргэн бүртэй ажиллах боломжгүй учир зарим төрлийн гэмт хэрэг өсөлттэй гарч байна.

Гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тодорхойлж, түүнийг арилгах үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлснээр тухайн төрлийн гэмт хэрэг /Хүснэгт 1/ болон нийт гэмт хэргийн тоо /Хүснэгт 4/ буурахад нөлөөлсөн байна.

1.3 Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн ялтай хүмүүсд захиргааны хяналт сайн тавигдаж байна.

Хорих ял эдлээд суллагдсан болон тэнсэн ял эдэлж байгаа хүмүүс дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдол 2015 онд 1 гарсан, 2016 онд гараагүй байна.

Энэ нь цагдаа, прокурорын байгууллагаас тавих хяналт болон тус хүмүүст зориулан зохион байгуулж байгаа төлөвшүүлэх сургалт, үйл ажиллагаа үр дүнтэй байгаатай холбоотой байна.

1.4 Гэмт хэргийн талаар иргэдээс төлбөртэй мэдээлэл авахгүй байна.

ГХУС тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 14.1³, 19.3.6⁴ дахь заалтууд хэрэгжихгүй байна.

Цагдаагийн газраас “Иргэдээс гэмт хэргийн тухай мэдээллийг төлбөртэй авах” журмын төслийг аймгийн ИТХ-д хүргүүлсэн боловч хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлээгүй байна.

Хууль, цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтэд тэр бүр хүрч ажиллах боломжгүй бөгөөд гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл өгөх хамгийн боломжит оролцогч бол иргэд юм.

Иргэдээс гэмт хэргийн талаар мэдээллийг төлбөртэй авснаар ГХУС ажилд оролцох иргэдийн идэвх нэмэгдэх хөшүүрэг болохоор байна.

³ Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага иргэдээс төлбөртэй авч болно

⁴ /гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх./

ГХУСАЗЗ болон Дундговь аймаг дахь Цагдаагийн газраас ААНБ-уудад ГХУС ажил зохион байгуулахтай холбоотой үүрэг, чиглэл өгч уриалга дэвшүүлдэг боловч байгууллагуудын идэвх оролцоо хангалтгүй байна.

Иймд Дундговь аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн журмын төслийг судалж иргэдээс гэмт хэргийн талаар мэдээллийг төлбөртэй авах ажлыг хууль, журмын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

1.5 ГХУС ажилтай холбоотой сургалт, сурталчилгаа үр дүнтэй зохион байгуулагдаж байна.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн 2015-2017 онуудад төлөвлөсөн үйл ажиллагаанд “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ мэдээллийг нэгтгэн, судалгаа шинжилгээ хийх, сургалт сурталчилгаа зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлэх” арга хэмжээ өндөр хувь эзэлж байна. /Хүснэгт 5/

Тус арга хэмжээний хүрээнд архинд донтох өвчтэй хүмүүсийн суурь судалгаа, малын хулгайн гэмт хэрэгтэй холбоотой судалгаа, бодлогын баримт бичиг, шүүхээр гэрлэлтээ цуцлуулсан хүүхдээ тэжээн тэтгүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэртэй хүүхдийн эрх, ахуй амьдралын судалгааг голлон хийж, ГХУС чиглэлээр санамж, сэрэмжүүлэг, мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа хийж ажилласан байна.

Тус судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа нь нийгэмд голлон гарч буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөл түүнийг арилгах арга хэмжээтэй уялдаж байна.

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоо болон согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо буурч байгаа нь сургалт, сурталчилгааны ажил үр дүнтэй зохион байгуулагдаж байгаатай холбоотой байна.

Бүлэг 2. ГХУС ажлын арга хэлбэр үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч төсөв хөрөнгө хүрэлцээгүйн улмаас зарим ажил хийгдэхгүй байна

2.1 ГХУС ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Хүснэгт 5

№	Хэрэгжүүлэх чиглэл, үйл ажиллагаа	2015	2016	2017
1	Удирдлага зохион байгуулалт	9	6	6
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ	12	12	10
3	Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн, судалгаа шинжилгээ хийх, сургалт сурталчилгаа зохион байгуулах	6	6	3
4	Хяналт, шалгалт	4	3	5
	Нийт дүн	31	27	24

Аймгийн ГХУСАЗЗ-ийн сүүлийн 3 жилийн төлөвлөсөн арга хэмжээг харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа нь ГХУС ажил, арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн, судалгаа шинжилгээ хийх,

сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлуудыг багасгаж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Нийт хэрэгжүүлэх ажлын дийлэнх хувийг ГХУС ажил, удирдлага зохион байгуулалт, судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа зохион байгуулах арга хэмжээ эзэлж байна. /Хүснэгт 4/

ГХУС ажлын хүрээнд 2015 онд 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлсний 7 нь буюу 58.3 хувийг “Архидан согтуурахтай тэмцэх” арга хэмжээ эзэлж байна.

Хүснэгт 6

Чиглэл	2015		2016		2017	
	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
Архидан согтуурах	7	58.3	7	58.3	2	20
Замын хөдөлгөөн	2	16.7				
Олон нийтийг идвэхжүүлэх	2	16.7	2	16.7		
Хүүхдийн эрхийн асуудал	1	8.3	1	8.3	6	60
Малын хулгай			1	8.3		
Шүүхийн асуудлаар			1	8.3		
Гэр бүлийн хүчирхийлэл					2	20
	12		12		10	

2016 онд мөн 12 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлсний 7 нь буюу нийт арга хэмжээний 58.3 хувийг “Архидан согтуурахтай тэмцэх” арга хэмжээ эзэлж байна.

Гэмт хэргийн ихэнх тохиолдол нь согтуугаар үйлдэгдсэн байдаг тул ГХУС ажил, арга хэмжээний дийлэнх хувийг “Архидан согтуурахтай

тэмцэх” арга хэмжээ эзэлж байгаа нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна. /Хүснэгт 1/

2017 онд нийт 10 арга хэмжээ төлөвлөсний 8 нь буюу нийт арга хэмжээний 80 хувийг “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийн эрхийн асуудал”-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ГХУСА33-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний хэрэгжилтийг авч үзэхэд хяналт шалгалтын чиглэлээр 2015 онд Амьтны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, ан амьтан агнаж болзошгүй газруудын хяналтыг сайжруулахад иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана гэж заасан боловч ажил зохион байгуулаагүй байна.

Мөн архидалттай тэмцэх сангийн ажиллах журам баталсан боловч, ажил хэрэг болон зохион байгуулагдаагүй нь төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдалтай холбоотой байна.

2.2 ГХУС ажлыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.

ГХУС тухай хуулийн дагуу Цагдаагийн газар нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар, 2015 оны 257 дугаар тогтоолын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа, хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолын хүрээнд:

Хүснэгт 7

2015 онд тус тогтоолын хүрээнд 8 чиглэлийн 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 4 чиглэлийн 21 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

252-р тогтоолын хэрэгжилт Цагдаагийн газар		Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хэрэгжилт
		Чиглэл	Арга хэмжээ	
2015 он	Хэрэгжүүлэх ёстой	8	30	70%
	Бүрэн хэрэгжүүлсэн	4	21	
2016 он	Хэрэгжүүлэх ёстой	7	25	100%
	Бүрэн хэрэгжүүлсэн	7	25	

Бүрэн хэрэгжүүлээгүй

арга хэмжээнд: “Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх” чиглэлийн 1 арга хэмжээ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх” чиглэлийн 3 арга хэмжээ, “Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх” чиглэлийн 3 арга хэмжээ, архи дан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 2 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь эдгээр арга хэмжээтэй холбоотой гэмт хэргүүд орон нутагт гарч байгаагүй, төсөв хөрөнгө хүрэлцээгүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

2016 онд 7 чиглэлийн 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан, бусад ААНБ, ОУБ, төсвийн байгууллагатай хамтран бүрэн хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 257 дугаар тогтоолын хүрээнд:

Хүснэгт 8

Тус тогтоолын хүрээнд 2015 онд 4 чиглэлийн 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 3 чиглэлийн 10 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

257 тогтоолын хэрэгжилт Цагдаагийн газар		Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хэрэгжилт
		Чиглэл	Арга хэмжээ	
2015 он	Хэрэгжүүлэх ёстой	4	12	83%
	Бүрэн хэрэгжүүлсэн	3	10	
2016 он	Хэрэгжүүлэх ёстой	3	10	100%
	Бүрэн хэрэгжүүлсэн	3	10	

Бүрэн хэрэгжүүлээгүй арга хэмжээний хувьд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэхэд иргэд, олон нийтийн зүгээс гаргасан санал, санаачилгад цагдаагийн байгууллага мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах шинэлэг арга хэлбэрийг хэрэгжүүлэх” чиглэлийн хүрээнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шилдэг нийтлэл, нэвтрүүлэг шалгаруулах уралдааныг хэвлэл мэдээллийн байгууллага /телевиз, радио, сонин сэтгүүл/, сэтгүүлчдийн дунд зарлан явуулах,
- Оюутан залуусыг сайн дурын үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, жуулчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор “Оюутан цагдаа” хөтөлбөр, арга хэмжээг нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэн ажиллах зэрэг 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

2016 онд 3 чиглэлийн 10 арга хэмжээг төлөвлөн өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь ГХУС ажлыг гүйцэтгэхэд орхигдуулсан чиг үүрэг байхгүй болохыг харуулж байна.

Аймгийн Прокурорын газраас 2015 онд ГХУС чиглэлээр 16 шалгалт хийсэн бол 2016 онд 8 шалгалт буюу өмнөх оноос 2 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн газартай хамтран Баянжаргалан, Өндөршил сумын ГХУССЗ-ийн үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдаж буй эсэхийг үзэж хангалтгүй ажилласан сумдад мэдэгдэл хүргүүлэн, мэдэгдлийн хариуг хүлээн авсан байна.

Хүснэгт 9

Ажлын үзүүлэлт			Прокурор	
			2015	2016
Бичсэн мэдэгдэл	Бүгд		17	28
	Хариу ирүүлсэн		13	28
Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хийсэн судалгаа			11	5
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалтанд оролцсон удаа			16	8
Хууль сурталчилсан талаар	Хийсэн зөвлөгөөн, ярилцлага, мэдээлэл		26	28
	Хамрагдсан хүн		1033	
	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр	Сонин хэвлэл	3	3
		Радио телевиз	1	6
		Вэб сайт	6	10

Мөн аймгийн төвийн 2 албан байгууллага, Сайнцагаан сумын 4 багийн ГХУС талаар хийсэн ажлуудыг шалгаж 3 багт мэдэгдэл хүргүүлсэн байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, ГХУС ажил зохион байгуулах талаар 2015 онд 17 мэдэгдэл хүргүүлснээс 13 мэдэгдэлд хариу

ирүүлсэн, 2016 онд 28 мэдэгдэл хүргүүлснээс бүх мэдэгдлийн хариуг хүлээн авсан байна.

Хууль сурталчлах зөвлөгөөн, ярилцлагыг 2015 онд 26 удаа, 2016 онд 28 удаа хийсэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2015 онд 10 мэдээлэл, 2016 онд 19 мэдээлэл хийсэн байна.

Хууль сахиулах байгууллагууд нь хуульд заасан тус тусын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага нь ГХУС ажлыг голлон гүйцэтгэж байгаа бөгөөд Прокурорын газар цагдаагийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял оногдуулах үйл ажиллагаанд хяналт тавих түвшинд ГХУС ажлыг гүйцэтгэж байгаа ба чиг үүргийн давхардал гараагүй байна.

2.3 ГХУСАЗЗ, ГХУССЗ-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажил хангалтгүй байна.

ГХУСАЗЗ-ийн 2015-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэх журам гарган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тус ажил хийгдээгүй.

Сумдын салбар зөвлөлийн ажлыг зөвхөн сумдын ИТХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд ордог ГХУССЗ-ийн ажлын үр дүнгийн 3 шалгуураар дүгнэж байна.

Сумдын ГХУССЗ-ийн 2016 оны ажлыг ИТХ-аас үнэлж Сайнцагаан, Говь-Угтаал, Дэлгэрцогт сумдын ГХУССЗ-ийг сайн үнэлгээ өгч шалгаруулсан боловч ямар шалгуур үзүүлэлтээр үнэлэсэн нь тодорхойгүй байна.

Иймд сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэх журмыг боловсруулан шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ажлын үр дүнг үнэлж ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 3. ГХУС үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдахгүй байна.

3.1 ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасан хэмжээнд төлөвлөхгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁵-д заасны дагуу төсвийг төлөвлөж, санхүүжүүлэхгүй байна.

2015 онд Замын хөдөлгөөн, хэв журмын зөрчлөөс 101.4 сая төгрөгийн орлогыг төсөвт тушааж, тус орлогын 40 хувь буюу 40.6 сая төгрөгийг 2016 оны ГХУС үйл ажиллагаанд зарцуулах ёстой боловч төсвийг 4.6 сая төгрөгөөр дутуу буюу 36.0 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 10 /сая төгрөг/

	Замын хөдөлгөөн, хэв журмын зөрчлөөс төсөвт тушаасан орлого	Орлогын 40%	ГХУС зардлын батлагдсан төсөв	Батлагдсан төсөв болон хуульд заасан санхүүжилтын хэмжээний зөрүү
2015	101.4	40.6	31.0	
2016	161.6	64.6	36.0	4.6
2017			30.7	33.94

2016 онд замын хөдөлгөөн, хэв журмын зөрчлөөс 161.6 сая төгрөгийн орлогыг төсөвт тушааж, тус орлогын 40 хувь буюу 64.6 сая төгрөгийн орлогыг

2017 оны ГХУС үйл ажиллагаанд зарцуулах ёстой боловч төсвийг 33.9 сая төгрөгөөр дутуу буюу 30.7 сая төгрөгөөр баталсан байна.

ГХУС ажлын төсвийг хуульд заасан хэмжээнээс багаар баталснаас зарим ажлууд хийгдэхгүй байна. Тухайлбал сумдын ГХУС үйл ажиллагаанд очиж хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сургалт сурталчилгаа явуулах боломжгүй, иргэдээс гэмт хэргийн талаар мэдээллийг төлбөртэй авах, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглаж чадахгүй байна.

Иймд ГХУС ажилд зарцуулах төсвийг ГХУС тухай хуульд заасны дагуу төлөвлөж, санхүүжүүлж байх асуудлыг нэгдсэн байдлаар холбогдох байгууллагаар шийдүүлэхээр ҮАГ-т санал хүргүүлээ.

3.2 2015, 2016 онуудад ГХУС ажилд зарцуулсан төсвийн 15.6 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

⁵ 19.1. Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

2015 онд ГХУС ажилд 32.7 сая төгрөг зарцуулсны 14.6 сая төгрөг буюу 48.0 хувийг олон нийтийн цагдаагийн урамшуулалд, 9.8 сая төгрөг буюу 32.2 хувийг сургалт, сурталчилгаанд, 5.8 сая төгрөг буюу 19.1 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2016 онд ГХУС ажилд 35.0 сая төгрөг зарцуулсны 17.1 сая төгрөг буюу 48.8 хувийг олон нийтийн цагдаагийн урамшуулалд, 6.7 сая төгрөг буюу 18.9 хувийг сургалт, сурталчилгаанд, 4.4 сая төгрөг буюу 12.5 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Хүснэгт 11 /сая төгрөг/

Зардлын зүйл	2015		2016		2017	
	Зардлын гүйцэтгэл	Эзлэх хувь	Зардлын гүйцэтгэл	Эзлэх хувь	Зардлын гүйцэтгэл	Эзлэх хувь
Олон нийтийн цагдаагийн урамшуулал	14.6	48.0	17.1	48.8	6.8	80.7
Цагдаагийн хэрэглэл	0.2	0.7	5.5	15.7	-	-
Сургалт, сурталчилгаа	9.8	32.2	6.6	18.9	1.5	18.2
Шагнал урамшуулал	-	-	1.4	4.1	0.1	1.2
Зориулалт бус	5.8	19.1	4.4	12.5	-	-
Нийт	30.4		35.0		8.5	

2016 оны ГХУС зардлын бүтцийг графикаар харуулбал:

График 3



2015, 2016 онд нийт 10.2 сая төгрөг буюу нийт зардлын 15.6 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь төсвийг үйл ажиллагаа, арга хэмжээ бүрээр нарийвчлан төлөвлөдөггүй, ГХУС ажлыг зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлдэггүйтэй холбоотой байна.

Үүний улмаас ГХУС ажил бүрэн хэрэгжихгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагавартай байна.

ГХУС зардлаас 2015-2016 онд ИТХ-ын ажлын албаны ажилчдын албан томилолт, 4 жилийн үйл ажиллагааны тайланг хэвлүүлэх, аймгийн Засаг даргын хэрэгжүүлсэн "Иргэний оролцоо-Хөгжлийн бодлого" сэдэвт бага хурлын хоолны төлбөр зэрэг ИТХ-ын ажлын албаны зардалд 10.2 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4-д /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно;/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.2-д /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна/ гэж заасан боловч 2015-2017 онд сумдад төсөв хуваарилаагүйгээс зарим сумдын гэмт хэргийн тоо өсөлттэй гарсан байна.

Иймд сумдын гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан сумын Засаг даргад төсөв хуваарилж байх талаар аймгийн ИТХ-д зөвлөмж хүргүүлээ.

3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Төсвийг зориулалт бусаар зарцуулж байгаа, батлагдсан төсвийг арга хэмжээ бүрээр хуваарилаж төлөвлөдөггүй, ГХУСАЗЗ-өөр хэлэлцүүлдэггүй зэрэг нь төсөвт тавих хяналт хангалтгүй байх, хяналт хийх нөхцөл бүрдэхгүй байх үндэс болж байна.

Иймд төсвийг чиг үүрэг, арга хэмжээ бүрээр нарийн төлөвлөж, зөвлөлөөр хэлэлцүүлж, хяналт хийлгэж байх талаар аймгийн ГХУСАЗЗ-д зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

- Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг оновчтой тогтоон ажилласан байна.
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.
- Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн ялтай хүмүүсд захиргааны хяналт сайн тавигдаж байна.
- Гэмт хэргийн талаар иргэдээс төлбөртэй мэдээлэл авахгүй байна.
- ГХУС ажилтай холбоотой сургалт, сурталчилгаа үр дүнтэй зохион байгуулагдаж байна

ГХУС ажлын арга хэлбэр үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч төсөв хөрөнгө хүрэлцээгүйн улмаас зарим ажил хийгдэхгүй байна

- ГХУС ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.
- ГХУС ажлыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.
- ГХУСАЗЗ, ГХУССЗ-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажил хангалтгүй байна.

ГХУС үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдахгүй байна.

- ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасан хэмжээнд төлөвлөхгүй байна.
- 2015, 2016 онуудад ГХУС ажилд зарцуулсан төсвийн 17.8 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах саналыг холбогдох эрх бүхий байгууллагаар нэгдсэн байдлаар шийдүүлэхээр ҮАГ-т уламжилж байна. Үүнд:

- ГХУС ажилд зарцуулах төсвийг ГХУС тухай хуулийн 19.1-д заасны дагуу төлөвлөж, санхүүжүүлж байх.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ИТХ-д

- Сумдын гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан сумын Засаг даргад төсөв хуваарилж байх;
- Дундговь аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн журмын төслийг судалж иргэдээс гэмт хэргийн талаар мэдээллийг төлбөртэй авах ажлыг хууль, журмын хүрээнд шийдвэрлэх;

ГХУС ажлыг зохицуулах зөвлөлд:

- Төсвийг чиг үүрэг, арга хэмжээ бүрээр нарийн төлөвлөж, зөвлөлөөр хэлэлцүүлж, хяналт хийлгэж байх.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн ГХУСАЗЗ-ын даргад санал тайлбар авахаар хүргүүлсэн боловч заасан хугацаанд хариу ирүүлээгүй тул санал тайлбаргүй гэж үзлээ.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 1/23

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын хавсралтын 5 дугаар заалт, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг /ҮАГ-ГАГ/2017/09-ГА/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зөвлөмж)-ыг хавсралтаар баталсугай.

3. "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, ГХУСА33, аймгийн Цагдаагийн газар, тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн ГХУСА33-ийн дарга /С.Сүхбаатар/-т зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА



D:\office\Tushaal\A4\ГХУС report баталгаажуулах тухай.docx

0000000035

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудиторын 2017 оны 10 дугаар сарын
23-ны өдрийн 10 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: ҮАГ-ГАГ/2017/09-ГА

Аудитын нэр: “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”
/ сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн мян.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрөөс 2015-2016 онд ИТХ-ын ажлын албаны ажилчдын албан томилолт, 4 жилийн үйл ажиллагааны тайланг хэвлүүлэх, аймгийн засаг даргын хэрэгжүүлсэн "Иргэний оролцоо-Хөгжлийн бодлого" сэдэвт бага хурлын хоолны төлбөр зэрэг ИТХ-ын ажлын албаны зардалд ГХУС зардлаас санхүүжүүлсэн байна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4, Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.2	10.2			10.2		1	10.2
2	Сумдад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан төсөв хуваарилахгүй байна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.2						1	
3	ГХУС ажлын зардлын төсвийг хуулийн дагуу төлөвлөж, санхүүжүүлэхгүй байна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1						1	
4	Төсвийг чиг үүрэг, арга хэмжээ бүрээр нарийн төлөвлөж, зөвлөлөөр хэлэлцүүлдэггүй, хяналт хангалтгүй байна.							1	
Дүн			10.2	-	-	10.2		4	10.2

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР